



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН ЯАМ



СОЁЛЫН ЯАМ



Архивын ерөнхий  
газар




Монголын Үндэсний  
музей

ЭРХЭМ ХҮНДЭТ ..... ТАНЫГ

ҮНДЭСНИЙ АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН  
ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ "ХХ ЗУУНЫ МОНГОЛ БА ГУРВАН ХУВЬСГАЛ"  
СЭДЭВТ АРХИВЫН БАРИМТ, ЭД ӨЛГИЙН ҮЗЭСГЭЛЭНД ХҮРЭЛЦЭН  
ИРЭХИЙГ УРЬЖ БАЙНА.

ХААНА: МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙ  
ХЭЗЭЭ: 2021 ОНЫ 7 ДУГААР САРЫН 8-НЫ 14:00 ЦАГ



Улаанбаатар хот  
2021 ОН

## МЭНДЧИЛГЭЭ



XX зууны Монголын түүхэнд олон чухал үйл явдал тохиосны дотор ач холбогдол, цар хэмжээгээрээ 1921 оны Ардын хувьсгал буюу Үндэсний ардчилсан хувьсгал онцгой байр суурь эзэлнэ.

Ардын хувьсгал нь Монголчууд эрх чөлөө, тусгаар тогтнолоо бататган бэхжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, үндэсний дэвшилд хүрэх түүхэн эргэлтийг хийж, урагшлан хөгжих шинэ цагийн эхлэл болсон.

1921 оны Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулан Монголын Үндэсний музейтэй хамтран зохион байгуулж байгаа энэхүү үзэсгэлэн нь XX зууны Монголын гурван хувьсгалын үйл явц, залгамж холбоог нийтэд таниулан сурталчилж байгаагаараа онцлог юм.

XX зууны Монголын түүхэнд холбогдох данс хараа, архивын баримтууд Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагддаг. Тэдгээрээс дээжлэн толилуулж буй энэхүү үзэсгэлэнд Монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал, XX зууны Монголын гол үйл явдлаар тодорсон 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгал, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоосон 1990 оны Ардчилсан хувьсгалын түүхэнд холбогдох баримтуудыг дэлгэн үзүүллээ. Үүнд, Богд гэгээнтнээс Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээх цаг болсон тухай буулгасан лүндэн, Орос, Хятад, Монгол гурван улсын Хиагтын гэрээ, Ардын түр засгийн газар байгуулсан тогтоол, Ардын Засгийн газар, Богд хааны хооронд байгуулсан Тангаргийн гэрээ, Судар бичгийн хүрээлэн байгуулсан тухай Богд хааны зарлиг, Харилцан туслалцах хоршоо байгуулсан тухай Богд хааны зарлиг, 1945 оны тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалтын нэгтгэсэн үр дүн, Нэгдсэн Үндэстний Байгууллагад элсэн орсон тухай баримтууд, 1992 оны Үндсэн хууль зэрэг 60 гаруй архивын баримт, гэрэл зураг багтаж байна.

Монголчууд бидний үүсгэн байгуулсан, тэмцэж хамгаалсан, зүтгэн хөгжүүлж байгаа бүрэн эрхт Монгол Улс маань үеийн үед мандан бадарч байх болтугай.

Та бүхэн “XX зууны Монгол ба гурван хувьсгал” үзэсгэлэнд саатан морилно уу.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН

ДАРГА

  
С.ЭНХБААТАР

## МЭНДЧИЛГЭЭ



XX зуунд монголчууд тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй дархан байдлаа баталгаажуулах, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн олж авсан тэмцлийн он жилүүд байлаа.

1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан Архивын ерөнхий газартай хамтран “XX зууны Монгол ба гурван хувьсгал” тусгай үзэсгэлэнг дэглэн үзүүлж байна.

Гурван хувьсгалын залгамж холбоо нь Монголын түүхийн үйл явцад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд хоорондоо салшгүй, харилцан нэг нэгнээ нөхсөн залгамж холбоотой байв.

Энэхүү түүхт ой бидэнд баялаг сургамж үлдээж, бас бахархалт ирээдүйд тэмүүлэх ухаалаг бүтээлч, санаа бодол төрүүлэх, цаглашгүй оюуны баялаг, өв сан болон үлджээ.

Тус үзэсгэлэнгээс 1911 оны Үндэсний эрх чөлөөний, 1921 оны Үндэсний ардчилсан, 1990 оны Ардчилсан хувьсгалуудын үнэ цэнэ, залгамж холбоог, архивын баримт, музейн үзмэр, эд өлгийн зүйлээс судалгааны ач холбогдол, үзэгчдэд таашаал өгөх өнгө үзэмж, агуулга зэргийг харгалзан, сорчлон дэглэсэн бөгөөд түүхийг нэн сонирхолтой хэлбэрээр хүлээн авах болно гэдэгт итгэлтэй байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ЗАХИРАЛ,  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ,  
ДОКТОР, ПРОФЕССОР

*Д.Сүхбаатар*  
Д.СҮХБААТАР



## ӨМНӨТГӨЛ

Хорьдугаар зуун нь Монгол Улсын Үндэсний тусгаар тогтнолоо сэргээж бататгахын төлөө тууштай тэмцсэн тэмцлийн зуун байсан юм. Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн гольдролд нэгдэхэд 1911, 1921, 1990 онуудад өрнөсөн улс төрийн үйл явц шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ хувьсгалууд нь хоорондоо салшгүй холбоотой, залгамж чанартай хувьсгал байв.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин Улсын ноёрхлыг түлхэн унагаж, VIII Богд Жибзундамба хутагтыг хаан ширээнд залж, төрт ёсны өнө эртний уламжлал, төрийн тусгаар тогтнолоо сэргээсэн юм. 1920 оны 1 сард ДИУ нь Гадаад Монголын автономит эрхийг цэрэг зэвсгийн хүчээр далайлган устгасан нь монголчуудыг тусгаар тогтнолоо сэргээх их тэмцэлд босгосон.

1921 оны 7 сард Ардын журамт цэрэг, Улаан армийн ангиудын хамт Нийслэл Хүрээнд орж ирэхэд Богд хаант Засгийн газрын төлөөлөгчид хадаг барин талархан угтсанаар Нийслэл Хүрээнд Ардын хувьсгал тайван замаар ялалтанд хүрчээ. Энэ хувьсгал нь агуулга, шинж чанараараа Үндэсний ардчилсан хувьсгал байв.

Энэ хувьсгалын үр дүнд нийгэм, эдийн засгийн эрс өөрчлөлтийг хэрэгжүүлсний дотор хамжлагын харилцааг халж, засаг захиргааны зохион байгуулалтад шинэчлэл хийж, үндэсний эдийн засаг, банк санхүүгийн тогтолцоог бий болгох, соёл боловсролыг хөгжүүлэх бодлогыг явуулсан. 1924 онд Улсын анхдугаар Их хурал хуралдаж, тус улсын түүхнээ анх удаа “Үндсэн хууль” батлан, Ардын эрхт Бүгд Найрамдах Улсыг зарлан тунхаглажээ.

Хувьсгалын эхний жилүүдэд улс орны хөгжлийн хэтийн төлөвийн талаар үндэсний ардчилсан болон хэт хувьсгалчирхаг зүүний хүчний хооронд улс төр, үзэл бодлын зөрөлдөөн үүссэн юм. Коминтерн эл зөрөлдөөнийг улам дэвэргэн, улс төрийн эргэлтийг зохион байгуулж, Монголд нийгэм журамт ёсыг тогтоох зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэхийг оролдсон нь улс төрийн гүнзгий хямралыг бий болгосон.

1932 оны 6 сарын сүүлчээр хуралдсан МАХН-ын Төв Хороо, Хянан Байцаах Төв Комиссын хавсарсан III Онц бүгд хурлаар зүүний алдаа завхралыг засах шийдвэр гаргасан юм. Энэхүү шийдвэр нь түүхэнд “Шинэ эргэлтийн бодлого” хэмээн алдаршжээ. “Шинэ эргэлтийн бодлого”-ын жилүүдэд орчин үеийн аж үйлдвэрийн суурь тавигдаж, малын тоо толгой 1932 онд 16,2 сая байсан бол 1940 онд 26 сая болж өсчээ. Үндэсний соёл, боловсрол хөгжиж, 1935 онд нийт хүн амын 5,6 хувь нь бичигтэн байсан бол 1940 онд 20,8 хувь болж нэмэгджээ.



1941 онд ЗХУ-д эх орны дайн эхэлснээр Монголын нам засгаас улс ардын аж ахуйг дайны нөхцөлд зохицуулан удирдаж, Зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөнийг бүх нийтийн хэрэг болгон зохион байгуулсан. 1945 оны II сард Ялтад хуралдсан ЗХУ, АНУ, Их Британий Засгийн газрын тэргүүн нарын бага хурлаар ЗХУ-ын саналын дагуу Гадаад Монголын статус-квог зөвшөөрөхөөр тогтсон нь тус улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх эхлэл болсон.

1945 оны 10 сарын 20-ны өдөр БНМАУ-ын тусгаар тогтнолыг батлах бүх ард түмний санал хураалт явагдаж, нийт сонгогчдын 98.6% оролцож, бүгд тусгаар тогтнолоо баталснаар ДИУ-ын Засгийн газар 1946 оны 1 сарын 5-нд БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн.

Дэлхийн II дайны дараа 1954 онд хуралдсан МАХН-ын XII их хурлаас “социализмын материал, техникийн баазыг байгуулах” зорилтыг дэвшүүлж, нам төрийн бүхий л үйл ажиллагаа социалист байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэгдэв. 1959 оны эцсээр атар газар эзэмшиж, газар тариалан хөдөө аж ахуйн бие даасан салбар болон хөгжиж, хөдөө аж ахуйд нэгдэлжих хөдөлгөөн ялж, социалист үйлдвэрлэлийн харилцаа тогтов. Хөнгөн хүнсний болон уул уурхайн үйлдвэрүүдийг шинээр байгуулах буюу шинэчлэн тоноггосноор БНМАУ хөдөө аж ахуйг аж үйлдвэрийн орон болох замд шилжжээ.

Хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг үндсэнд нь арилгаж, боловсролын нэгдсэн систем тогтсон ба мөн хүн ам эрүүлжин өсч, эрчин үеийн эмнэлгийн үйлчилгээг хүртэх болсон байна. Энэ үе бол Монголын ард түмэн улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх I, II таван жил, гурван жил, III таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө шаргуу хөдөлмөрлөсөн он жилүүд байлаа.

1960 оноос хойш Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг аж үйлдвэрийн шинэ хотуудыг байгуулж, тулш эрчим хүч уул уурхайн үйлдвэрүүдийг хөгжүүлэх бодлого баримталжээ. 1961 онд БНМАУ НҮБ-ын 101 дэх гишүүн улс болж, дэлхийн хамтын нийгэмлэгт зүй ёсны байр сууриа эзэлсэн юм.

1960-аад оноос Монголын улс төрийн амьдралын хүрээнд хүнд суртал, захиран тушаах тогтолцоо бүрэлдэж, авторитар дэглэм ноёрхон, 1980-аад оноос Монголд социализм өөрийн чадавхиа шавхаж, мухардмал байдалд орсон.

1990 оны Цагаан морин жилд монголчууд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжин, нийгэм улс төрийн цоо шинэ тогтолцоог сонгон Ардчилсан хувьсгалыг тайван замаар хийсэн.


Ийнхүү XX зууны Монголын гурван хувьсгал нь улс төрийн тусгаар тогтнолоо бүрэн олж, эдийн засгийн бие даасан байдлыг хангахын төлөө тэмцэн, сэргэн мандлын замдаа эргэлт буцалтгүй орсон.



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДАЛБАА

Хэмжээ: 156 x 113 см


Материал: Торго



Тулгар төрийг нээж, шашин төрийг хослон дэлгэрүүлсэн өдрийг жил бүрийн өвлийн дунд сарын шинийн есөнд тэмдэглэх тухай Богд хааны зарлиг

1912.01.11

МУУТА,Х.А-173, Д-1. ХН-72



**БОГД ХААНЫ МУТРЫН ТЭМДЭГ**


Хэмжээ: 1.5 x 1.5 см

Материал: баргилт чулуу





Халхын дөрвөн аймгийн хан, ван, бэйс, засаг жич, хамба шанзудба нараас Монгол орон манжаас тусгаарласан тухай зарласан ухуулах бичиг  
1911.12.01  
МУУТА, Х.А-2. Д-1. ХН-1



**УЛСЫН ЭРХ**

Хэмжээ: 19 x 13 см  
Олноо өргөгдсөний 14 дүгээр он буюу 1924 онд Монгол Ардын Намын Төв Хорооноос Нийслэл Хүрэн дэх Орос Монголын Хэвлэлийн хороонд хэвлэн гаргажээ. Тус номыг Агийн Буриад Жамсрангийн Цэвээн Монгол Улсын ерөнхийлөн захирах сайд Сайн ноён ханы тушаасныг хичээнгүйлэн дагаж, Улсын дотоод эрхүүдийг товчлон тодорхойлон бичсэн байна.



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᣳᠠᠨ  
ᠵᠢᠷᠯᠢᠭᠠᠭᠠᠷ ᠵᠢᠷᠰᠠᠨ ᠡᠯᠴᠢᠨ ᠰᠠᠶᠢᠳᠢᠨ ᠲᠠᠮᠭ᠋ᠠ  
ᠠᠨᠬᠤᠨᠠᠶᠢᠨ ᠳᠢᠯᠢᠮᠠᠲᠤ ᠠᠶᠢᠯᠴᠢᠯᠠᠯᠠᠨ ᠮᠣᠳᠣᠨ ᠲᠠᠮᠭ᠋ᠠ


**“МОНГОЛ УЛСЫН ЗАРЛИГААР ЗАРСАН ЭЛЧИН САЙДЫН ТАМГА” БУЮУ  
АНХНЫ ДИПЛОМАТ АЙЛЧЛАЛЫН МОДОН ТАМГА**

1912 он

Хэмжээ: 10.5 x 10.5 см

Жин: 160 гр

1912 оны Орос-Монголын найрамдлын гэрээ байгуулагдсаны дараа гэрээний зарим асуудлыг тодорхой болгох үүднээс Богд хаан Хаант Орос улсад зарах элчин сайдад Гадаад Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэх Яамны тэргүүн сайд, Эрдэнэ дайчин чин ван Ханддоржийг томилсон ба төлөөлөгчид олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу уг тамгыг үйлдэн авч явжээ.



Орос, Хятад, Монгол гурван этгээдийн гэрээ. Хиагт хот  
1915 он  
МУУТА, Х-4. Д-1. ХН-37а





**МОНГОЛ АРДЫН НАМЫН ТАМГА**

1920 он

Хэмжээ: 5 x 5 см


Жин: 17 гр

Монгол орны цаг төрийн байдал туйлын ээдрээтэй болсон үе буюу 1918 оны сүүл, 1919 оны эхээр Нийслэл хүрээнд бий болсон нууц 2 бүлгэм эх орноо чөлөөлөх тэмцэлд олон түмнийг удирдан зохион байгуулахын тулд 1920 оны VI сарын 25-нд "Монгол ардын нам" хэмээх улс төрийн байгууллагад нэгджээ. Д.Догсомын тэмдэглэлд Монгол Ардын Намын тамгыг Зүүн хүрээний бүлгэмийг үндэслэгч С.Данзангийн зандан ширээний хөлөөр Консулын дэнжийн бүлгэмийг үндэслэгч Д.Бодоо урласан тухай бичиж үлдээсэн байна.





ЗОУ-д тусламж хүсэж очсон Монголын хувьсгалчид тус бүрийн хийж гүйцэтгэх ажлыг хуваарилсан бичиг  
Эрхүү хот. 1920.08.24  
МУУТА, УТНОНБА, Х.1, Д.1, ХН.20



Монголын хувьсгалчдын ЗОУ-аас тусламж хүссэн бичгийн анхны эх ноорог  
1920 он  
МУУТА. УТНОНБА.ХУХ-1, Д.1, ХН-7



Таван яамыг сэргээн байгуулж сайд нарыг томилсон тухай бичиг  
1921.02.25  
МУУТА, ХА-3, Д-1, ХН-1146, Б-18



Орос жанжин генерал Баронд үе улиран ханыг зэрэг, Дархан хошой чин вангийн хэргэм, ногоон жууз, улбар шар хүрэм, шар жолгоо, гурван нүдэт тогосын отго, улсыг мандуулагч их баатар жанжин цолоор шагнасан Богд хааны зарлиг  
1921 он  
МУУТА, ТБА, ХА-173, Д-1, ХН-222, Б-1



Монгол Ардын Засгийн Хэргийг Түр Захиран Шийтгэх Газрын тэргүүлэгчдийн зөвлөлдөж тогтоосон хурлын тогтоол  
1921.07.07  
МУУТА, УТНОНБА. Х.4, Д.1 ХН.16, Х.1-4





АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ШИНЭ ТӨРИЙН ЭЗЭД ИРЛЭЭ

Зураач: Б.Гомбосүрэн

1952 он

Хэмжээ: 180x83 см

Материал: холст, тосон будаг



Монгол Ардын Засгийн Хэргийг Түр Захиран Шийтгэх Газар байгуулсан тухай тогтоол

1921.03.13

МУУТА. ТБА. Х.1, Д.1, ХН.1






МОНГОЛ УЛСЫН СҮР ХҮЧИЙГ БАДРУУЛАГЧ АРДЫН ЖУРАМТ ИХ ЦЭРГИЙН  
ЖАНЖИН ТУГ

Хуулбар

Хэмжээ: 335 x 218 см



Үндэсний төв архивт хадгалагдан буй 1921 оны Үндэсний  
ардчилсан хувьсгалын партизан нарын бүртгэл хуудас  
1931 он



Ардын Засгийн газар ба Богд хааны хооронд байгуулсан тангаргийн гэрээ

1921.11.01

МУУТА. ТБА. Х.1, Д.1, ХН.9, х.32



### МОНГОЛ УЛСЫН АРДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ БАРИХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТАМГА

1921 он

Хэмжээ: 6.2 x 6.2 см

Жин: 570 гр

1921 оны 9 дүгээр сарын 27-нд Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Гадаад Яамны тэргүүн сайд Д.Бодоогийн шийдвэрээр Зөвлөлийн Засагт Их Орос улсын Засгийн газартай худалдаа нэвтрүүлэх зэрэг гэрээ бичиг хэлэлцэн тогтоохоор Сангийн яамны тэргүүн сайд, МАН-ын Төв Хорооны дарга С.Данзан, Цэргийн яамны тэргүүн сайд Д.Сүхбаатар, Гадаад яамны орлосон дэд сайд Б.Цэрэндорж нарт бүрэн эрх олгож томилон илгээжээ. Тэрхүү бүрэн эрх барих төлөөлөгчдөд энэхүү тусгай тамга үйлдэн олгосон байна.



Зөвлөлт Орос, Монгол хоёр улсын  
хэлэлцээр  
1921 оны 11 сарын 05




Монгол Улсын Харилцан туслалцах хоршоо байгуулж, даргаар Д.Чэгдаржавыг тохоон  
томилох тухай Богд хаанд өргөсөн айлтгал, буулгасан зарлиг  
1921 он  
МУУТА, ТБА, ХА-173, Д-1, ХН-222, Б-16



Судар бичгийн хүрээлэн байгуулах тухай Богд хаанд өргөсөн айлтгал, буулгасан зарлиг  
1921 он 11 сарын 13  
МУУТА. ТБА. Х.23, Д.1, ХН.2, Б.1





1921 ОНД САНГИЙН ЯАМНЫ САЙД С.ДАНЗАНГИЙН САНААЧИЛГААР ХЭВЛҮҮЛСЭН  
АРДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АНХНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Хэмжээ: 25-тын дэвсгэрт: 16 x 9.2 см

10-тын дэвсгэрт: 16.3 x 8.4 см

Энэхүү мөнгөн тэмдэгт нь 1921 онд "Доллар" хэмээх нэртэйгээр хэвлэгдсэн боловч гүйлгээнд гаргаагүй юм. Уг цаасан дэвсгэртийг Москва хотын Гознак хэвлэлийн үйлдвэрт хэвлэжээ



## МОНГОЛ УЛСЫН СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ТАМГА

1922 он


Хэмжээ: 6.8 x 6.8 см

Жин: 925 гр



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ТӨРИЙН ДАЛБАА  
1924 он  
Торго, даавуу





**БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн бичмэл эх**  
1924 он  
МУУТА. ТБА. Х.11, Д.1, ХН-3

Монголд ардын засаг тогтсоны дараа Шүүх яамны сайд Магсаржав хурц, Ж.Цэвээн, Бат-Очир нар үндсэн хуулийн төсөл боловсруулж байв. Нам, төрийн удирдагчдын дунд хагарал үүсэж, үндсэн хуулийн төсөл боловсруулах ажил удааширсан. 1924 оны 5 дугаар сарын 20-нд Богд хаан таалал төгссөний дараа Үндсэн хууль боловсруулах шинэ комиссыг Ерөнхий сайд Б.Цэрэндорж, Ж.Цэвээн, Э.Ринчино нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан юм. ЗХУ-ын хууль, цаазын мэргэжилтэн П.В.Всесвятскийг зөвлөхөөр ажиллуулсан. 1924 оны 11 дүгээр сарын 8-нд нээгдсэн Монгол Улсын анхдугаар Их хурал 15 хоногийн хугацаанд хуралдахдаа Үндсэн хуулийг зүйл бүрээр хэлэлцэн 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан.

Анхдугаар Үндсэн хууль нь оршил, "Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь", "Улсын дээд эрхийг барих газрын тухай", "Нутгийн захиргааны тухай", "Сонгох, сонгогдох эрхийн тухай", "Улсын орлого зарлагын тухай", "Улсын тамга ба сүлд тэмдэг, туг далбаа гурвын тухай" хэмээх 6 бүлэг, 50 зүйлээс бүрдэж байв. Үндсэн хуулиар бүх шатны ардын хурал нь шинэ төрийн үндэс болохыг ийнхүү хуульчлан бататгахын хамт ард түмнээс төрийн хэрэгт оролцох эрх чөлөөг Монголын түүхэнд анх удаагаа тунхаглан заасан юм.



**БНМАУ-ЫН АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛЬ**  
1924 он XI сард Улаанбаатар хотноо хэвлэсэн  
Хэмжээ: 13 x 19.8 см



ЦЭЦЭРЛЭГ МАНДАЛ АЙМГИЙН ЦЭРГИЙН ТУГ

1920-иод он  
Хэмжээ: 180 x 160 см  
Торго, дурдан



### БИЧГИЙН ГАВЬЯАНЫ ОДОН


Бүтээлч: Цэрэндорж Сампилон, Б.Шарав  
Хэмжээ: 53 x 48 см, Жин: 32.16 гр  
1926 онд Улсын 3 дугаар их хурлаас бичгийн албан хаагчдыг гавьяа байгуулсанд одон тэмдэг шагнах тухай "Бичгийн гавьяа"-ны одонгийн гурван анги, 12 зүйлтэй дүрмийн хэлэлцэн баталжээ. Хожим 1930 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 29 дүгээр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор "Аж ахуйн гавьяаны" одон хэмээн нэрлэхээр тогтжээ.



### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОН

Бүтээлч: Цэрэндорж Сампилон, Б.Шарав  
Хэмжээ: 53 x 48 см, Жин: 32.16 гр  
Монгол Ардын нам байгуулах хувьсгалт нууц бүлгэмийн ажлаас эхлэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан авах, бататган бэхжүүлэх зэрэг хувьсгалын үйл хэрэгт идэвхтэй оролцож явсан Улсын Бага хурлын гишүүн, Бүх цэргийн жанжин Х.Чойбалсан, Улсын Бага хурлын гишүүн, Цэргийн явдлын яамны сайд Хатанбаатар Магсаржав нарыг БНМАУ-ын "Цэргийн гавьяа"-ны одон тэмдгээр шагнажээ.





Нийслэл хотын нэрийг “Улаанбаатар хот” хэмээн нэрлэж, нийтээр журамлан дагаж явуулахаар тогтсон БНМАУ-ын анхдугаар Их хурлын 14 дүгээр тогтоол 1924.11.26. МУУТА, X.11, Д.1, ХН.1, X.74



А.Д.Симуковын зохиосон Монгол Ард Улсын нутгийн захиргааны зураг  
Анхны 13 аймгийн хил хязгаар, засаг захиргааг тэмдэглэжээ  
1933 он



### БНМАУ-ЫН СҮЛД

1940 онд БНМАУ-ын III их хурлаар баталсан Үндсэн хуулиар улсын сүлд тэмдгийг өөрчлөн БНМАУ-ын сүлд нь дугуй хэлбэртэй дунд нь Монгол Улсын хангай, тал, говь нутгаар наран ургах зүг уургаа барин давхиж буй морь унасан ард байх бөгөөд дугуйны хөвөөгөөр өвс ногооны дээгүүр таван хошуу малын толгойг хоёр талаар нь зурж, дугуй дээд талыг дан алхан хээгээр хүрээлж, дунд таван хошуу тэмдэг байрлуулсан байна. Сүлдний туузан дээр улсын нэрийг монгол үсгээр "Бүгд Найрамдах Монгол Ард Улс" гэж бичсэн байхаар тогтжээ.





БНМАУ-ын хоёрдугаар Үндсэн хуулийн эх  
1940 он



БНМАУ-ын төрийн далбаа  
1945 он

БНМАУ-ын далбаа нь 2:1 хэмжээтэй улаан ба хөх өнгийн эдээр үйлдэх бөгөөд үүнд уртын гуравны нэг хувийн хэмжээгээр дундаа агаарын адил хөх өнгөтэй байх ба гуравны хоёр хувь нь болох түүний хоёр тал нь улаан өнгөтэй байна. Ишинд уях талын улаан дэвсгэрийн дунд талд алтан шар өнгийн таван хошуу байх ба түүний доод талд мөн адил шар өнгөөр үйлдэгдсэн бөгөөд бадамлянхуа цэцэггүй соёмбо байна



**МАРШАЛ Х.ЧОЙБАЛСАНГИЙН ГАРЫН ТЭМДЭГ**  
Хэмжээ: 2,9 см, голч: 2 см



**Монгол Улсын Их сургуулийн хичээлийн нээлт**  
1942 он



**“Гитлерт үхэл” хэмээн бичсэн их бууны сумыг хүлээлгэн өгч байгаа нь**  
1943 он



**Хувьсгалт Монгол танкийн цувааг ЗХУ-ын Улаан армид гардуулж буй нь**  
1943 он





**УХУУЛАХ ХУУДАС**

Зураач: П.Балдандорж

Хэмжээ: 20 x 30 см

"Би Бүгд Найрамдах Монгол Ард Улсын харьяат мөн. Хүн болж төрсний минь дээд зэргийн эрхэм сайхан эрмэлзэл бол өөрийн эх орны тусгаар тогтнолын төлөө амь бие ба санаа сэтгэлээ зориулахад хэзээ ч бэлхэн байхад оршино" хэмээжээ. Тус ухуулах хуудсыг улсын хэвлэлийн газар 1000 хувь хэвлэсэн байна.



**БНМАУ-ЫН ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДЛААР ЯВУУЛСАН БҮХ НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС**

1945 оны ЗСБНХУ, АНУ ба Англи гурван гүрний удирдагчдын Ялтын бага хуралд Гадаад Монголын (БНМАУ-ын) бодитой оршин буйг тухайн үеийн хилээр нь тогтоох шийдвэр гаргасан байна. Ийнхүү 1945 оны 10 дугаар сарын 20-нд Монголын бүх ард түмэн тусгаар тогтнолоо нотолсон санал хураалтыг явуулжээ.



Наушкиас Улаанбаатар хот хүртэл төмөр замын шугам тавих, ашиглахын тулд “Улаанбаатар төмөр зам” хувь нийдүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр

1949.06.06



БНМАУ-ын Ерөнхий сайд Х.Чойбалсан, Наушки-Улаанбаатарын төмөр замаар ЗСБНХУ-с БНМАУ-д суугаа элчин сайд анхны галт тэрэг орж ирэв Ю.Приходов нар Наушки-Улаанбаатарын 1949.11.07 төмөр замын барилгын ажилтай танилцав 1949 он







БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХҮРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

**Зарлиг**


1954 он 4 дугаар сарын 4 өдөр, дугаар 25  
Улаанбаатар хот

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийг явуулах тухай.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийг явуулах адршлыг сонгууль болох хугацаагаас 2 сарын өмнө зарлах ба сонгуулийг алхын бус өдөр явуулах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийн тухай дүрэм-ийн 29 дүгээр зүйл: өөссөө бооноор Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийг 1954 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн өмнө гэржт явуулсуугаа.
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийн хамтлагийг 1954 оны 4 дүгээр сарын 10-ноос өмнө зарлаасуугаа.

Б. Н. М. А. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга  
Б. Н. М. А. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга  
Б. Н. М. А. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга



БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ИХ ХҮРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

**Зарлиг**

1954 он 2. дугаар сарын 8 өдөр, дугаар 55  
Улаанбаатар хот

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийг явуулах тухай.

Б.Н.У.А.Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийг явуулах адршлыг сонгууль болох хугацаагаас 2 сарын өмнө зарлах ба сонгуулийг алхын бус өдөр явуулах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын сонгуулийн тухай дүрэм-ийн 29 дүгээр зүйл: өөссөө бооноор Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга  
Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга  
Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга



БНМАУ-ын Их хурлын сонгууль явуулах тухай Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар зарлиг  
1951.04.09

БНМАУ-ын аймаг, хот, сум, хороо, баг, хориний хөдөлмөрчдийн депутатуудын сонгуулийн явуулах тухай Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 55 дугаар зарлиг  
1952.07.08

110
113

МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

УЛС ОРОН ДАЯАР СОЁЛЫН ДОВТЛООН ЯВУУЛАХ ТУХАЙ

1959 оны 9 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

УЛС ОРОН ДАЯАР СОЁЛЫН ДОВТЛООН ЯВУУЛАХ ТУХАЙ

Монголын ард түрэн МАХН-ын тусгаарлах дор аугаа их Зөвлөлт Засвар Улсын их дунгийн тусламжаар хөгжсөөн өртө хөгжилтэй гэгдсэн, хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

Зөвлөлт Засвар Улсаар явуулагдахын социализмд ачирхайн орнуудын хамтын ажиллагаа тургэн зөгчлөх, тусламжийг хоорондын ажиллагааг өргөжүүлж, хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

МАХН-ын Төв Хорооны 8 бтгд хурал манай урч ардын их ахуйн их салбарт социализмд ачирхайн хөгжилтэй ажиллагааг хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

МАХН-ын Төв Хорооны 8 бтгд хурал социализмд өргөн фронтоор байгуулах явцад хурал өргөн бос социализмыг өргөн өргөжүүлж, хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

Уг үйлдлийн явцад зарим ба олон жилийн байгууллагуудад ...

Энэ өргөн фронтоор социализмд өргөн фронтоор байгуулах ажиллагааг хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооныс ТУТГОХ нь:

1. Манай орон социализмд өргөн фронтоор байгуулах хөгжилтэй ажиллагааг өргөжүүлж, хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

Өргөн фронтоор өргөн фронтоор байгуулах ажиллагааг хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

Архивчид өргөн фронтоор байгуулах ажиллагааг өргөжүүлж, хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

Хамтын ажиллагаа нь манай орон болох социализмд ачирхайн буюу орон социализмыг барих явцад зөвөгч ажилни орох байсан бололцоог эвч байсан.

“Улс орон даяар соёлын довтолгоон явуулах тухай” МАХН-ын Улс Төрийн Товчооны 249 дүгээр хурлын тогтоол  
1959.07.13  
МУУТА, УТНОНББА, Х.4, Д.24, ХН.195, Х.110-118




**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН СҮЛД**

1960 он

Хэмжээ: 40 x 40 см

Даавуун дээр зээглэж оёсон.

1960 оны 7 дугаар сарын 6-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас үндсэн хуулийг шинэчлэн баталжээ. Энэхүү үндсэн хуулинд БНМАУ-ын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж, цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн хэмээн нийгмийн хөгжлийн ямар чиг шугам баримталж явахыг тодорхойлсон байна.







**1960 ОНЫ ҮНДСЭН ХУУЛЬ ЗЭЭГТ  
НААМАЛ**

1971 он

Хэмжээ: 220 х 136 см

Ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулсан уран бүтээлийн үзэсгэлэнд урган хатгалч Б.Норолхоо урлан тавьжээ


**“КАПИТАЛИЗМЫГ  
АЛГАСЧ”**

Ардын зураач Д.Амгалан

1961 онд зуржээ

Улсын хэвлэлийн комбинат





Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг НҮБ-ийн гишүүнээр элсэх хүсэлтээ илэрхийлэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга, Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, Улсын маршал Х.Чойбалсангаас НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Трюви Ли-д бичсэн өргөдөл

1946.06.24

МУУТА, ТБА, Х-1, Д-4, ХН-41, Х.4-7



НҮБ-д элсэхээр Монгол Улсаа төлөөлж очсон Гадаад явдлын яамны орлогч сайд, эрдэмтэн зохиолч Д.Цэвэгмид тэргүүтэй Б.Жаргалсайхан, Б.Дашцэрэн, Б.Ванчиндорж нарын дипломатууд Нью-Йорк хотноо Нэгдсэн Үндэстний байгууллагын төв байрны өмнө төрийнхөө далбааг анх мандуулав. 1961.10.27





**1978 ОНД АШИГЛАЛТАНД ОРСОН УУЛЫН БАЯЖУУЛАХ ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭРИЙН  
ЗЭСИЙН ХАЙЛШ  
1981.III.30**

“Монголын Эрдэнэт ба зөвлөлтийн Жезказганы зэсийн хайлш бол манай ард түмний бат найрамдлын бэлгэдэл юм. Зөвлөлт – Монголын хамтарсан сансарын багийн газардсан өдөр “1981 оны III сарын 30” гэсэн бичиг зэс хутгуурдаж буй дүрслэл бүхий зэсийн хайлш



**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
САНСРЫН НИСГЭГЧ Ж.ГҮРРАГЧААГИЙН  
“СОЮЗ -39” ХӨЛГИЙН БҮХЭЭГТ АВЧ ЯВСАН  
“ЛЕНИНТЭЙ УУЛЗСАН НЬ” БАРИМАЛ**

1981 он  
Уран барималч Лувсанцэрэнгийн Дашдэлэгийн  
бүтээл

**МОНГОЛ УЛС**



**БНМАУ-ЫН 2 САЯ ДАХЬ ИРГЭНИЙ ДУРСГАЛЫН ТЭМДЭГ  
1988 он**

Монгол Улс 1963 онд анх удаа 1017.1 мянга буюу нэг сая хүнтэй болсон байдаг бол үүний дараа 1988 оны 7 дугаар сарын 11-нд төрсөн 25 хүүхдийг 2 сая дахь иргэн хэмээн батламжилжээ



### МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН СҮЛД

1992 оны Монгол Улсын шинэ Үндсэн хуулинд баталсан төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байхаар заажээ. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийн бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн улаан хээ ашид дэвшихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлжээ.





МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН  
ХУУЛЬ  
1992 он  
Хэмжээ: 20 x 13 см

### Монгол Улсын төрийн далбаа

Хэмжээ: 200 x 100 см

Монгол Улсын үндсэн хуулийг 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 12.00 цагт улс даяар даган мөрдөж эхэлснийг нийтэд зарлан тунхаглаж, нийслэл Улаанбаатар хотноо Д.Сүхбаатарын талбайд төрийн шинэ бэлгэ тэмдгийг өргөн мандуулах ёслол үйлдэн, энэ үеэр нийт аймаг, хот, сум, хороо дүүрэг, орон нутгийн төвд ёслолын цуглаан хийж ёслол үйлдэх мөчид



Монгол Улсын төрийн шинэ далбааг төрийн ордон, аймаг, хот, сум, хороо, дүүрэг орон нутгийн хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанд хүндэтгэлтэйгээр өргөн мандуулахыг зарлиг болгосон байна.